



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 147

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Жаргалант сумын Буянт багийн нутаг дэвсгэр Усан бассейны урд талд байрлах авто гражны зориулалттай Батмөнхийн Энхтайван /ПИ82031875/-ийн эзэмшлийн 26.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Түмэнжаргалын Хаш-Эрдэнэ /ПН85072912/-д 14 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Наран багийн нутаг дэвсгэр “Цагаан морь” түүхий эдийн зах байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай Нэргүйн Баатарням /УС71030710/-ийн эзэмшлийн 5371.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Дашзэвэгийн Лхамсүрэн /МД58102575/-д мэдээллийн сангийн зургийн дагуу 5270 метр квадрат, хаягийг Эрх чөлөө 2 дугаар гудамжны 239 тоот болгон 5 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэдтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/147 Ch

02 00672